БАТЛАВ.

"БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН"
ҮТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭРДЭНЭБАЯР

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ, МЭДЛЭГ, БАЙР СУУРИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр № Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Ерөнхий шаардлага
1	Судалгааны ажлын үндэслэл	• Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг. • Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр "Бүсийн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулахыг даалгасан. • Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг бүс бүрд зохион байгуулж, бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс бүрд хэрэгжүүлэх шаардлагатай 5 мега төслийн жагсаалт гаргахыг даалгасан.
2	Судалгааны хамрах хүрээ	• Үндэсний хэмжээнд 6 бүс болон нийслэл Улаанбаатар хотын төлөөллийг хамруулан бүсчилсэн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн мэдээлэл, мэдлэг, төсөөлөл, байр суурийн талаарх олон нийтийн санаа бодлын хүрээнд энэхүү судалгааны ажлыг явуулна.
3	Судалгааны ажлын зорилго	• Үндэсний хэмжээнд "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын талаарх иргэдийн ойлголт, мэдээллийг тодорхойлох

		• Үндэсний хэмжээнд "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын талаарх иргэдийн мэдлэгийг үнэлэх • Бүс, орон нутгийн хэмжээнд бүсчилсэн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн төсөөлөл, хандлагыг үнэлэх • Бүс, орон нутгийн хэмжээнд бүсчилсэн хөгжлийн бодлогын талаарх иргэдийн байр суурийг тодорхойлох • "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын талаарх иргэдийн мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох
4	Ажлын иж бүрдэл	Судалгаа хийж гүйцэтгэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. • Судалгааны арга зүй боловсруулах • Судалгааны дизайн боловсруулах • Судалгааны түүвэр тодорхойлох • Судалгааны тайлан боловсруулах • Санал зөвлөмж боловсруулах
5	Судалгааны арга зүй	Судалгааг нийгмийн эмпирик судалгааны тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан гүйцэтгэнэ. • Тоон судалгааны түүврийн хэмжээг 3000 иргэн хамруулахаар тодорхойлж, 7 бүсийн төлөөллийг хангахуйц хэмжээнд байна. Анкетыг нүүр тулсан ярилцлагын аргаар авна. • Чанарын судалгааг фокус бүлгийн ярилцлагын аргаар авна. Хамрах хүрээний хувьд бүс бүрд 1 удаа, нийслэл Улаанбаатар хотод 4 удаа, нийт 10 удаагийн ярилцлага хийгдэнэ. Ярилцлага бүр 8 хүртэлх оролцогчтой байна.
6	Захиалагч байгууллага	"Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ
7	Тендерт оролцогчийн багийн гишүүдэд тавигдах шаардлага	Зөвлөх хуулийн этгээд нь нийгмийн эмпирик судалгааны ажлын туршлагатай, судалгааны ажил гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг чадвартай хүний нөөц болон тоног төхөөрөмжтэй байна.
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 1 сар
9	Гүйцэтгэгч байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд

10	Санхүүжилт, эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
11	Хүлээн авах баримт	Тоон болон чанарын судалгааны үр дүнг боловсруулан, график, хүснэгт хэлбэрээр дүрсэлж, дүн шинжилгээ, дүгнэлтийг агуулсан хэлбэрээр нэгтгэн тайлагнана.